




“Инвекор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 5- дугаар сарын 19-ний өдрийн 22 тоот Тогтоолын Нэгдүгээр Хавсралт



“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

IC-15 V-2.0

2023 он

| | |
|---|---|
| <i>Хамрах хүрээ:</i> ИНВЕСКОР ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчид | <i>Хариуцах нэгж:</i> Төлөөлөн удирдах зөвлөл |
| <i>Хувийг хадгалах:</i> Гүйцэтгэх захирал | <i>Танилцах:</i> ИНВЕСКОР ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал |
| <i>Хүчинтэй хугацаа:</i> 2023 оны 05-р сарын 19-ний өдрөөс эхлэн | <i>Дараагийн үнэлгээ хийх хугацаа:</i> 2023 оны 05-р сарын 19-ний өдрөөс эхлэн |
| <i>Журмын дугаар:</i> IC-15 | <i>Хувилбар:</i> V-2.0 |
| <i>Хуудасны тоо:</i> 5 | |

Өөрчлөлтийн түүх

| № | Хувилбар | Өөрчлөлт хийгдсэн огноо | Өөрчлөлтийн агуулга |
|----|----------|-------------------------|---|
| 1. | V- 1.0 | 2019.02.18 | Эхний хувилбар |
| 2. | V-2.0 | 2023.05.19 | Давуу эрхийн хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотойгоор өөрчлөн найруулав. |
| 3. | | | |
| 4. | | | |
| 5. | | | |
| 6. | | | |
| 7. | | | |

“ИНВЕСКОР ББСБ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү ногдол ашгийн бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг төлөх, хувьцаа эзэмшигчид болон зохицуулагч байгууллагад мэдээлэл өгөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү бодлого нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн Дүрэм болон зохицуулагч байгууллагаас баталсан аливаа дүрэм, журмуудад нийцсэн байх ба Компанийн ногдол ашиг хуваарилах, төлөх ажиллагаанд тэдгээрийг мөрдлөг болгоно.
- 1.3. Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай удирдаж, ногдол ашгийг тогтвортой байлгах, өсгөхийг зорьж ажиллана.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- 2.1. Компани нь холбогдох бүх төрлийн албан татварыг төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах ба нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- 2.2. Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон нөхцөлийн дагуу тэргүүн ээлжинд ногдол ашиг авах эрхтэй байна.
- 2.3. Компани дор дурдсан нөхцөл бүрэн хангагдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
 - 2.3.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангаж байх;
 - 2.3.2. Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, Компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 2.3.3. Компани хувьцаа эзэмшигчийн шаардлагаар гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авах нөхцөл үүссэн, өрийн хэрэгслээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн худалдаж авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх;
 - 2.3.4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал нь Компанийн тогтвортой үйл ажиллагааг хангахуйц байх;
 - 2.3.5. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчид төлөх ногдол ашгийг бүрэн төлсөн байх.
- 2.4. Компани дор дурдсан нөхцөл бүрэн хангагдсан тохиолдолд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
 - 2.4.1. Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
 - 2.4.2. Компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх.
- 2.5. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон нийгэмд хандсан арга хэмжээ зохион байгуулах сан байгуулж болно.

- 2.6. Энэхүү Бодлогын 2.4-т заасан тусгай зориулалтын сан байгуулахдаа тэдгээрт зохих хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байхаар тооцно.
- 2.7. Энэхүү Бодлогын 2.4-т заасан тусгай зориулалтын сан байгуулах шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг Гүйцэтгэх захирал боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөл батлан мөрдүүлнэ.
- 2.8. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд Гүйцэтгэх захирал нь ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг эзэлдүүлэгч нарт бичгээр мэдэгдэнэ.
- 2.9. Компанийн хувьцаа эзэмшигч нь нас барсан, татан буугдсан зэрэг эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол ногдол ашиг авах эрхийг өв залгамжлалын эсхүл эрх залгамжлалын үндсэн дээр гуравдагч этгээдэд шилжүүлнэ.

Гурав. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- 3.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулан санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт нэг энгийн болон давуу эрхийн хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг хуваарилах тайлангийн үе, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, ногдол ашиг хуваарилах арга (зуучлагч байгууллагаар дамжуулах эсэх), ногдол ашиг хуваарилалтын тайланг гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлэх тухай тусгаж энэ талаарх мэдээллийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт хүргүүлнэ.
- 3.2. Ногдол ашгийг нэн тэргүүнд мөнгөн хэлбэрээр хуваарилах бөгөөд шаардлагатай тохиолдолд эд хөрөнгийн эрх, эсхүл Компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 3.3. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
- 3.4. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх хэлбэр, хугацаа, журмын талаар бүрэн тусгана.
- 3.5. Компани нь энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.
- 3.6. Компани ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журмын дагуу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэнэ.
- 3.7. Журмын 3.6-д заасан мэдээлэлд тухайн төрлийн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, ногдол ашиг хуваарилах хэлбэр, ногдол ашгийг төлөх хугацаа, компани өөрөө, эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан төлөх эсэх, мэргэжлийн зуучлагч байгууллагын нэр, хаяг, ногдол ашиг тараах байгууллагын ажиллах цагийн хуваарь, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгасан байна.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, төлөх

- 4.1. Компани нь давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг бүрэн төлсөн болон эргүүлэн худалдаж авах үүрэг бүхий давуу эрхийн хувьцааг худалдаж авсны дараа Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилж болно.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4-р сарын 14-ний өдрийн ээлжит хурлаас тогтоосон нөхцөлийн дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд жил бүр ногдол ашиг хуваарилах үүргийг Компани хүлээнэ.
- 4.3. Давуу эрхийн хувьцааны тухайн тайлант жилийн ногдол ашгийг дараа жилийн 4 сарын 30-ны өдрийн дотор төлнө.
- 4.4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Хувьцаат компанийн ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь дансанд шилжүүлэх бодлого баримтална.

Тав. Мэдээлэх, тайлагнах

- 5.1. Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед “Ногдол ашгийн хуваарилалтын тайлан”-г гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.

Зургаа. Хариуцлага

- 6.1 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хугацаанд төлөөгүйгээс Компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх захирал болон холбогдох бусад албан тушаалтнууд хариуцна.
- 6.2 Энэхүү бодлого болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд буруутай этгээд нь хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

--oOo--

